



## БАЯНХОНГОР АЙМАГТ 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2022 оны 01 дүгээр сарын 31


Номгон

### НЭГ: ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1. Тус цагдаагийн газар нь 2022 оны 1 дүгээр сард иргэн, аж ахуйн нэгжээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 482 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 128 буюу 37 хувиар өссөн. Үүнээс 153 буюу 32 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 329 буюу 69 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол,  
мэдээллийн шийдвэрлэлт:

Зөрчлийн шинжтэй гомдол,  
мэдээллийн шийдвэрлэлт:




Хүлээн авч шалагасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 69, зөрчлийн шинжтэй 46 нийт 115 буюу 24 хувь нь шийдвэрлэгдээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 9 буюу 6 хувийг 5 хоногт, 75 буюу 49 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 278 буюу 85 хувийг 3 хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

### ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд энэ оны 1 дүгээр сард 73 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 41 нэгжээр буюу 1,3 дахин өссөн байна.



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 55 хэрэг бүртгэгдсэнээс 11 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 20 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8.2 пунктээр өссөн байна.


**63%** буюу

**46** нь Баянхонгор сум




**37%** буюу


**27** нь бусад сумдад



### Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал




### Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



**Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:**


Бүртгэгдсэн гэмт хэргийн 62 буюу 85 хувь нь хөнгөн ангилалын, 11 буюу 15 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.




**Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:**

Хэргийн ангилал	Өссөн дүнгээр			
	2021 оны 01 сар	2022 оны 01 сар	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
Хүний амьд явах эрхийн эсрэг	1	0	-1	-100%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байлын эсрэг	16	20	4	25%
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг /үүнээс/	3	5	2	67%
Хүчиндэх	2	2		
Хулгайлах /үүнээс/	7	9	2	29%
Иргэдийн өмчийг хулгайлах	6	8	2	34%
Тээврийн хэрэгслийн хулгай	1	1		
Мал хулгайлах	0	16	16	100%
Дээрэм	0	1	1	100%
Залилах	3	7	4	1.3 дахин
ӨААҮАӨ	0	2	2	100%
Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг	1	1		
Бусад	1	15	14	14 дахин


**Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:**



**Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг**




**Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /тухайн сараар/:**



### Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 15 буюу 21 хувь нь согтуугаар, 6 буюу 9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 6 буюу 9 хувь нь бүлэглэн, 1 буюу 2 хувь нь хүүхэд оролцож, 8 буюу 11 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.




### Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 32 гэмт хэргээс 17 буюу 53,1% нь гэр орон сууцанд, 3 буюу 9,3 % нь гудамж талбайд, 2 буюу 6,2 % нь олон нийтийн газар, 2 буюу 6,2% нь төрийн байгууллагад, 8 буюу 25% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:




Үйлдэгдсэн цаг:




### Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 64 иргэн хохирч, үүнээс 23 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10 нэгжээр буюу 77 хувиар өсч, нас барсан хүн бүртгэгдээгүй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1 нэгжээр буюу 100 хувиар буурсан.




Гэмт хэргийн улмаас 319.0 сая төгрөгийн хохирол учирснаас 21.0 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 7 хувьтай байна:



### Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 32 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 нэгжээр буюу 78 хувиар өссөн бөгөөд 5 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан нь 1,5 дахин, 8 хүн урьд ял шийтгэгдсэн нь 60 хувиар тус тус өссөн.



### **ГУРАВ: ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ**

Аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сард нийт 1429 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 зөрчлөөр буюу буурсан. Бүртгэгдсэн зөрчлийн 1402 буюу 99 хувийг шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн зөрчлөөс 1195 зөрчлийг ердийн журмаар 30058.5 төгрөгөөр, 160 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар 37595.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан 14 зөрчлийг 1400.0 мянган төгрөгөөр /нийт торгууль 69053.5/ тус тус торгож шийдвэрлэсэн байна.



Энэ хугацаанд 40 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь 11 нэгжээр буюу 38 хувиар, 60 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 6 хувиар өссөн байна.



Зөрчил үйлдэгдсэн онцлог:


Зөрчил үйлдэгдсэн байдал	2020.12 сар	2021.12 сар	/Өсөлт,бууралт/	Хувиар
Согтуугаар	126	167	41	33%
Хүүхэд оролцсон	2	0	-2	-100%
Эмэгтэй хүн оролцсон	9	32	23	2.5 дахин
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	13	26	13	100
Олон нийтийн газар	11	11		
Гэр орон сууцанд	38	76	38	100%
Гудамж талбайд	155	118	-37	-23%

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
06-12 цагт	290 буюу 21%	Даваа гараг	290 буюу 21%
		Мягмар гараг	225 буюу 16%
13-18 цагт	760 буюу 54%	Лхагва гараг	181 буюу 13%
		Пүрэв гараг	171 буюу 12%
19-24 цагт	305 буюу 22%	Баасан гараг	232 буюу 17%
		Бямба гараг	167 буюу 12%
01-05 цагт	74 буюу 6%	Ням гараг	163 буюу 12%

**Зөрчил үйлдсэн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл:**

Энэ хугацаанд 207 иргэн зөрчилд холбогдон шалгагдсанаас 36 буюу 17.3 хувь нь эмэгтэй, 70 буюу 33.8 хувь нь тус тус малчин болон ажилгүй, 33 буюу 15.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 12 буюу 5.7 хувь нь төрийн албан хаагч эзэлж байгаа нь бусад салбараас өндөр хувийг эзэлж байна.



Хорио цээрийн дэглэм зөрчсөн 3 иргэнд шүүгч баривчлах шийтгэл ногдуулсан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 28 иргэнээс 3 иргэнд шийтгэврээр торгох, 25 иргэнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

**Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл:**




1385 буюу **97** хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч

44 буюу **3** хувьд шүүгч

**Согтууруулах үндэс хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаа:**

Энэ хугацаанд 96 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 15 хувиар өсч, эрүүлжүүлэгдсэн хүний 75 буюу 79 хувийг гэр, орон сууцнаас, 8 буюу 9 хувийг гудамж талбайгаас, 5 буюу 6 хувийг байгууллага, аж ахуйн нэгжээс, 4 буюу 5 хувийг үзвэр, үйлчилгээний газраас, 1 буюу 1 хувийг зочид буудлаас, 1 буюу 1 хувийг бар цэнгээний газраас тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

**Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:**



Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 92 буюу 95 хувь нь эрэгтэй, 4 буюу 5 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

**НЭГ: ДҮГНЭЛТ**

Аймгийн хэмжээнд 2021 оны 01 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

**НЭГ. ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР:**

1.1. Тус цагдаагийн газарт 2022 оны 01 дүгээр сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 482 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 128 нэгжээр буюу 37 хувиар өссөн.

1.2 Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь нийт хүлээн авч шалгасан гомдол, мэдээллийн ачааллаар орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн хэмжээнд ДӨРӨВДҮГЭЭРТ, хангайн бүсийн 6 аймгаас ГУРАВДУГААР эрэмбэлэгдэж байна.

## **ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР:**

2.1. Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт 2022 оны 1 дүгээр сард нийт 73 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41 нэгжээр буюу 1.3 дахин өссөн.

2.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл: Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 25 хувиар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 67 хувиар, хулгайлах гэмт хэрэг 29 хувиар, мал хулгайлах, дээрэмдэх, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд тус тус 100 хувиар, залилах гэмт хэрэг 1,3 дахин бусад гэмт хэрэг 14 дахин **тус тус өсч**, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 100 хувиар **буурсан** байна.

2.3. Бүртгэгдсэн хэргийн 20 гэмт хэргийн 28 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 25 буюу 35 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 бүлгийн гэмт хэрэг нь нийт хэргийн 62 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд тогтвортой байгаа үзүүлэлт юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 63 хувь нь Баянхонгор суманд үйлдэгдсэн бөгөөд Баянхонгор суманд үйлдэгдсэн гэмт хэрэг 1,5 дахин, бусад сумдад үйлдэгдсэн гэмт хэрэг 93 хувиар тус тус өссөн нь аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 1,3 дахин өсөхөд шууд нөлөөлсөн.

Мөн зонхилон үйлдэгддэг мал хулгайлах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, иргэдийн өмчийг хулгайлах, залилах болон бусад гэмт хэргүүд өссөн нь нийт хэрэг өсөхөд нөлөөлсөн.

2.4. Нийт гэмт хэргийн гаралтаар орон нутгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын байдлаар ДОЛООДУГААРТ, хангайн бүсийн хэмжээнд ГУРАВДУГААРТ байгаа нь бусад орон нутагтай харьцуулахад эрүү хэв журмын нөхцөл байдал хүнд, алба хаагчид ачаалалтай ажиллаж байна гэж дүгнэхээр байна. Гэмт хэргийн гаралтаар НЭГДҮГЭЭРТ Өвөрхангай аймаг 138, ХОЁРДУГААРТ Орхон аймаг 116, ГУРАВДУГААРТ Хэнтий аймагт 105 бүртгэгдэн нь гэмт хэргийн гаралтаар эхний 3 аймагт багтаж байна.

2.5 Мал хулгайлах гэмт хэрэг 16 нэгжээр буюу 100 хувиар, залилах гэмт хэрэг 4 нэгжээр 1.3 дахин өссөн . Тэр дундаа залилах гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэх тохиолдол өссөөр байгаа нь онцгой анхаарал татаж байна.

## **ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:**

3.1. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 20 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар өссөн байгаа нь цагдаагийн алба хаагчдаас мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх ажиллагаа сайжирсны нэг илрэл юм.



## **ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ХОЛБОГДОГЧИЙН ТАЛААР:**

4.1. Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдийн нийгмийн байдлаар нь авч үзэхэд гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 10 буюу 31.2 хувь нь, гэмт хэрэгт өртөж хохирогчдийн 20 буюу 31,2 хувь нь, зөрчилд холбогдогчийн 70 буюу 33.8 хувь нь тус тус малчин иргэд байгаа нь тэдний хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Мөн төрийн албан хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдох явдал нь таслан зогсоогдохгүй байгаа тул шийдвэрлэгдсэн тухай бүр нь байгууллагад нь “Албан мэдэгдэл” хүргүүлж, үр дүнг нь тооцож ажиллаж, сахилга ёс зүйг нь сайжруулах шаардлагатай байна.

## **ТАВ. ЗӨРЧЛИЙН ТАЛААР:**

5.1. Аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сард нийт 1429 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 нэгжээр буурсан.

Зөрчил гаргасан нийт 1302 иргэнийг 69053.5 **төгрөгөөр торгосон**. Үүнээс 1056 буюу 81.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил байна.

5.2. Энэ хугацаанд эрүүлжүүлэгдсэн хүн 12 нэгжээр буюу 15 хувиар өссөн. Энэ хугацаанд эрүүлжүүлэгдсэн иргэдийн 75 буюу 79 хувь нь гэр орон сууцнаас эрүүлжүүлэгдсэн байгаа нь гэр бүл, ахуйн хүрээнд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх тохиолдол их байгаатай холбоотой байна.

## **САНАЛ**

1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нэг хором” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг аймгийн ГХУСАЗСЗ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
2. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр “Жаргалтай амьдрал” төвтэй хамтран ажиллах, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн криминологи судалгааны хүрээнд боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэх
3. Залилах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалтууд, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулах,
4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил удаа дараа үйлдэж буй иргэдэд чиглэсэн нэг бүрчилсэн хяналтыг хэрэгжүүлэх,
5. Мал сүргийг хулгайн гэмт хэргээс хамгаалах монголын нийгэмлэгийн Баянхонгор аймаг дахь салбартай хамтран ажил, арга хэмжээ зохион байгуулан малчдын бүлгэмийн ажлыг тасралтгүй эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, малчдыг сум, багийн хүрээнд эргүүлд томилгоожуулан хуваарьт оруулах, шаардлагатай тохиолдолд тэднийг урамшуулах.
6. Гэмт хэргийн гаралт өсөлттэй байгаа баг, сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөө сумдын иргэд, малчдыг мэдээллээр хангах, тэдэнд хууль, эрх зүйн

мэдлэг олгох зорилгоор сумдад урьдчилан сэргийлэх ажил, сургалт, сурталчилгааг зохион байгуулах,

7. Насанд хүрээгүй иргэн холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн гаралт өсч байгаад анхаарч, гэмт хэрэгт холбогдсон, хохирсон насанд хүрээгүй хүнд сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, холбогдож болзошгүй хүүхдүүдийг бүртгэлжүүлж эцэг, эх асран хамгаалагч нартай нь байнгын уялдаа холбоотой ажиллах, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд холбон зуучлах, цахим хэлбэрээр өсвөр насны хүүхдүүдэд сургалт сурталчилгааг тогтмол явуулах,

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Б.БЯМБАА

ТАНИЛЦСАН:

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.ОЮУТБОЛД